ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өвөрхангай аймгийн Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ӨВА-2022/110/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас:
www.audit.mn

Арвайхээр

2022 он


Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: О.Батжаргал

Утас: 70323253 Цахим хаяг: BatjargalO@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Гансүх

Утас: 70323833 Цахим хаяг: GansukhD@audit.gov.com

Аудитор: Б.Авидцэрэн

Утас: 70323833 Цахим хаяг: AvidtserenB@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Аудитын тайлан
3.1 Ерөнхий зүйл
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
3.4 Материаллаг байдал
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг
3.8 Аудитын гол асуудал
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал
4. Аудитын илрүүлэлт
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

## 1. Аудитын дүгнэлт

ӨВӨРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

62113 Арвайхээр, Өвөрхангай аймаг
Утас/Факс: (976) 7032 3253
E-mail: ovorkhangai@audit.gov.mn

2022.02.22 № 196

танай ________-ны № ________-т

БОЛОВСРОЛ, СОЁЛ, УРЛАГИЙН
ГАЗРЫН ДАРГА Ж.ПҮРЭВСҮРЭН
ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР [signature] О.БАТЖАРГАЛ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл /төгрөгөөр/

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **30123193.00** | **33768223.00** |
| **33** | **АВЛАГА** | **10750000.00** | **2000000.00** |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 1000000.00 | |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | 2000000.00 |
| 33500 | Бусад авлага | 9750000.00 | |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 9750000.00 | |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | **1484000.00** | |
| 34700 | Бусад урьдчилгаа | 1484000.00 | |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 1484000.00 | |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 1484000.00 | |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | **17889193.00** | **31768223.00** |
| 35400 | Хангамжийн материал | 17889193.00 | 31768223.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 473000.00 | 3626750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4575200.00 | 4702700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | | 2600000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | | 9000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 12840993.00 | 20829773.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)** | **123208525.27** | **146602896.42** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **123208525.27** | **146602896.42** |
| 39200 | Биет хөрөнгө | 122638108.41 | 146374979.48 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 15075396.00 | 15075396.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл - Барилга | -502513.20 | -753769.80 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 94800000.00 | 94800000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл | -46000000.00 | -50880000.04 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 122672235.62 | 160845560.62 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж | -75058350.50 | -80938191.59 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 32979356.80 | 32979356.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл - Тавилга | -21328016.31 | -24753372.51 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 570416.86 | 227916.94 |
| 39301 | Програм хангамж | 2202200.00 | 2202200.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж | -1631783.14 | -1974283.06 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **153331718.27** | **180371119.42** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **2968079.00** | |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **2968079.00** | |
| 41300 | Өглөг | 2968079.00 | |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1444861.16 | |
| 41312 | НДШ-ийн өглөг | 1444861.16 | |
| 41360 | Бусад өглөг | 1523217.84 | |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 1523217.84 | |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **150363639.27** | **180371119.42** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **150363639.27** | **180371119.42** |
| 51101 | -Төрийн | 168421979.43 | 168421979.43 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | -32105638.60 | -2098158.45 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -79538336.98 | -32105638.60 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 47432698.38 | 30007480.15 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 14047298.44 | 14047298.44 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **153331718.27** | **180371119.42** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1311057955.6** | **3323000013.2** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **53507555.6** | **174988244.2** |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 53507555.6 | 174988244.2 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 19907555.6 | |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 19907555.6 | |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 33600000.0 | 17953033.0 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал | | 157035211.2 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1257550400.0** | **3148011769.0** |
| 1310 | Улсын төсвөөс | 1247160400.0 | 2748213200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1247160400.0 | 2748213200.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10390000.0 | 399798569.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 10390000.0 | 149380780.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | | 250417789.0 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1007595434.2** | **3292992533.1** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1007595434.2** | **3292992533.1** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 369381026.2 | 864288676.6 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 132903376.0 | 290858083.0 |
| 210101 | Үндсэн цалин | 70759857.0 | 204901124.0 |
| 210102 | Нэмэгдэл | 48267373.0 | 63525693.0 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 9498110.0 | 10933630.0 |
| 210104 | Урамшуулал | 4378036.0 | 11497636.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16605234.0 | 38000622.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 6612334.0 | 26617996.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2498200.0 | 2918242.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1998600.0 | 2326864.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 499600.0 | 557956.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4996500.0 | 5579562.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 7015800.0 | 14031600.0 |
| 210304 | Байрны түрээс | 7015800.0 | 14031600.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5219867.8 | 178396850.2 |
| 210401 | Бичиг хэрэг | 1548500.0 | 2641650.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1995840.0 | 9377862.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 725077.8 | 1384727.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 50000.0 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 20200000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 900450.0 | 56000.0 |
| 210409 | Бараа материал шилжүүлсний зардал | | 144736611.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2901000.0 | 6797150.0 |
| 210604 | Урсгал засвар | 2901000.0 | 6797150.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 751800.0 | 4142000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 751800.0 | 4142000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, | 190624900.0 | 44487390.0 |

| | | | |
|---|---|---|---|
| | хураамж | | |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 190624900.0 | 43987290.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 180000.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 265100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 55000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13359048.3 | 287574980.9 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 245545710.0 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 3471280.0 | 15300509.0 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол | 9887768.3 | 26728761.9 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 638214408.0 | 2428703856.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 638214408.0 | 2245760627.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 29078100.0 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 325263840.0 | 1106681323.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 275982468.0 | 1086891504.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7890000.0 | 52187800.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 182943229.5 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 181490929.5 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 1452300.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **303462521.5** | **30007480.2** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **49693.5** | |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ | 49693.5 | |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 49693.5 | |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **303412828.0** | **30007480.2** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагд-сан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **168421979.4** | **14047298.4** | **-32105638.6** | **150363639.3** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 168421979.4 | 14047298.4 | -32105638.6 | 150363639.3 |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | | | | |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | | | | |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | | | | |
| 7 | Өмчид гарсан өөрчлөлт | | | | |
| 8 | Зарласан ноогдол ашиг | | | | |
| **9** | **Тайлант үеийн үр дүн** | | | **30007480.2** | **30007480.2** |
| | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **168421979.4** | **14047298.4** | **-2098158.5** | **180371119.4** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **1257550400.0** | **3148011769.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1257550400.0** | **3148011769.0** |
| 1310 | Улсын төсвөөс | 1247160400.0 | 2748213200.0 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1247160400.0 | 2748213200.0 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 10390000.0 | 399798569.0 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | 10390000.0 | 149380780.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | | 250417789.0 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **985541588.0** | **3125591669.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **985541588.0** | **3125591669.0** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 347327180.0 | 694677812.5 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 124911400.0 | 292302944.2 |
| 210101 | Үндсэн цалин | 94058400.0 | 204901124.0 |
| 210102 | Нэмэгдэл | 23904600.0 | 63525693.0 |
| 210103 | Унаа хоолны Хөнгөлөлт | 4752000.0 | 10933630.0 |
| 210104 | Урамшуулал | 2196400.0 | 12942497.2 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 16863000.0 | 38000622.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 11866600.0 | 26617996.9 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1249000.0 | 2918242.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 999200.0 | 2329864.5 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 249800.0 | 554956.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 2498400.0 | 5579562.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 4482600.0 | 14031600.0 |
| 210304 | Байрны түрээс | 4482600.0 | 14031600.0 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 2782200.0 | 35827406.8 |
| 210401 | Бичиг хэрэг | 244500.0 | 2840300.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1719100.0 | 9903612.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 407400.0 | 2276894.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 50000.0 | 105300.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 20200000.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 361200.0 | 501300.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2500000.0 | 279900.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 279900.0 |
| 210604 | Урсгал засвар | 2500000.0 | |
| 2107 | Томилолт, зочны зардал | 751800.0 | 2658000.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 751800.0 | 2658000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 190624900.0 | 44487390.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 190624900.0 | 43987290.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | | 180000.0 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | | 265100.0 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | | 55000.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4411280.0 | 267089949.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 245273440.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | 4411280.0 | 21816509.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 638214408.0 | 2430913856.5 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 638214408.0 | 2245970627.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 29078100.0 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжп | 325263840.0 | 1106681323.0 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчид төрөөс үзүүлэх дэмжлэг | 275982468.0 | 1086891504.0 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 7890000.0 | 52397800.0 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | | 184943229.5 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 181490929.5 |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 3452300.0 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **272008812.0** | **22420100.0** |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | | |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | **272008812.0** | **22420100.0** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **272008812.0** | **22420100.0** |
| 223 | БУСАД ХӨРӨНГӨ | **272008812.0** | 22420100.0 |
| 223004 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | **272008812.0** | 22420100.0 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | **-272008812.0** | **-22420100.0** |
| **9** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | | |
| **10** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | | |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | | |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)** | | |
| **14** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **15** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **71801** | **Сургуулийн өмнөх боловсрол** | **636796000.00** | **546602358.00** |
| **80231** | **Хүүхэд харах үйлчилгээ** | **0.00** | **0.00** |
| **80802** | **Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг** | **636796000.00** | **546602358.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **636796000.00** | **546602358.00** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **636796000.00** | **546602358.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 636796000.00 | 546602358.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **636796000.00** | **546602358.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **636796000.00** | **546602358.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **636796000.00** | **546602358.00** |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 385197000.00 | 296555724.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 251599000.00 | 250046634.00 |
| **71802** | **Ерөнхий боловсрол** | **1734269300.00** | **1646970469.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **1734269300.00** | **1646970469.00** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **1734269300.00** | **1646970469.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 1734269300.00 | 1646970469.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1734269300.00** | **1646970469.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1734269300.00** | **1646970469.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **1734269300.00** | **1646970469.00** |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 23262500.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 839624100.00 | 810125599.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 871382700.00 | 836844870.00 |
| **71808** | **Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага** | **377147900.00** | **373149443.51** |
| **80101** | **Үндсэн үйл ажиллагааны зардал** | **376819900.00** | **372821643.51** |
| **12** | **Татварын бус орлого** | **376819900.00** | **372821643.51** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **376819900.00** | **372821643.51** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 376819900.00 | 372821643.51 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **376819900.00** | **372821643.51** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **376819900.00** | **372821643.51** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **376819900.00** | **372821643.51** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **293568000.00** | **292302944.16** |
| 210101 | Үндсэн цалин | 205200000.00 | 204901124.00 |
| 210102 | Нэмэгдэл | 63600000.00 | 63525693.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11088000.00 | 10933630.00 |
| 210104 | Урамшуулал | 13680000.00 | 12942497.16 |

| | | | |
|---|---|---|---|
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **39631700.00** | **38000622.51** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 27889000.00 | 26617996.87 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2935700.00 | 2918242.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2348500.00 | 2329864.51 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 587100.00 | 554956.45 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5871400.00 | 5579562.68 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **14031600.00** | **14031600.00** |
| 210304 | Байрны түрээс | 14031600.00 | 14031600.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **14667300.00** | **14164406.84** |
| 210401 | Бичиг хэрэг | 2840300.00 | 2840300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 8368200.00 | 8440612.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2838800.00 | 2276894.84 |
| 210404 | Ном, хэвлэл | 118700.00 | 105300.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 501300.00 | 501300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **637400.00** | **632000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 637400.00 | 632000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж** | **2621100.00** | **2062570.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1726600.00 | 1562470.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 370000.00 | |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 180000.00 | 180000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 278500.00 | 265100.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 66000.00 | 55000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **11662800.00** | **11627500.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4723000.00 | 4688500.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 6939800.00 | 6939000.00 |
| **80802** | **Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг** | **328000.00** | **327800.00** |
| **12** | **Татварын бус орлого** | **328000.00** | **327800.00** |
| **12200** | **Тусламжийн орлого** | **328000.00** | **327800.00** |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 328000.00 | 327800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **328000.00** | **327800.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **328000.00** | **327800.00** |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **328000.00** | **327800.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 328000.00 | 327800.00 |
| **12000** | **Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |
| **12100** | **Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл** | | |
| **12200** | **Кассын дансны эцсийн үлдэгдэл** | | |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | **21** | **24** |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | **1** | **1** |

| | | | |
|---|---|---|---|
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | **20** | **23** |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 16 | 18 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 3 | 3 |
| 620004 | Гэрээт ажилтан | | 1 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Д/Д | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)** | | **399798569.0** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | | **399798569.0** |
| **210** | **БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | | **344276269.0** |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | | **21663000.0** |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 1463000.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | | 20200000.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | | **22700000.0** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | 22700000.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | | **2026000.0** |
| 210702 | Дотоод албан томилолт | | 2026000.0 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | | **42424820.0** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 42424820.0 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | | **255462449.0** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 240584940.0 |
| 210902 | Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх | | 14877509.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **55522300.0** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | | **52070000.0** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | 52070000.0 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | | **3452300.0** |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | | 3452300.0 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)** | | **399798569.0** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | | **399798569.0** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | | **399798569.0** |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан | | 149380780.0 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан | | 250417789.0 |
| **III** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | |
| **11000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **12000** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Авидцэрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Д.Гансүх, газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор О.Батжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Аймгийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 14 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Боловсрол, соёл, урлагийн газар нь үйлчилгээний хүртээмж, чанар нь тасралтгүй сайжирч, хүний хөгжилд байнгын түлхэц, дэмжлэг үзүүлэхүйц, өрсөлдөх чадавхитай боловсрол, соёлын үйлчилгээ үзүүлэх таатай нөхцөл боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг байгууллага юм.

Тайлант хугацаанд тус байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Газрын даргын 2014 оны 05 дугаар сарын 20-ний өдрийн А/30 дугаар тушаалаар батлагдсан "Боловсролын газрын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт зохион байгуулах журам", Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан журмыг мөрдөж, жилийн ажлын төлөвлөгөөг батлуулан ажилладаг байна.

Байгууллагын зохион байгуулалтын бүтцэд дотоод аудитын нэгж байхгүй.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Боловсрол, соёл, урлагийн газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн, хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 3,533.4 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 35.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70.0 хувь буюу 24.7 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Санхүүгийн тайланд үндсэн хөрөнгө, бараа материалын болон авлага, өглөгийн тодруулгыг бэлтгэжээ:

- Үндсэн хөрөнгө оны эхнээс 38.2 сая төгрөгөөр өссөн байгаа нь хөрөнгө оруулалтаар ирсэн тоног төхөөрөмж орлогод авсантай холбоотой байна.
- Бараа материалын үлдэгдэлд материаллаг өөрчлөлт ороогүй, 13.9 сая төгрөгөөр нэмэгджээ.
- Өглөгийн дансанд оны эхэнд байсан үлдэгдэл болох 3.0 сая төгрөгийг барагдуулснаар тайлант хугацааны эцэст өглөггүй гарсан байна.
- Урьд онд авлагын дансанд үлдэгдлээр тайлагнасан 12.2 сая төгрөгийн авлагыг барагдуулж, он дамжин хэрэгжиж буй төслийн санхүүжилтийн үлдэгдэл 2.0 сая төгрөгийг шинэ онд буцааж авахаар төвлөрүүлснийг авлагад тусгасан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төслийг хуулийн хугацаанд бэлтгэж, аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст нэгтгүүлж ирсэн байна. 2021 оны төсвийн төсөлд нийт зардлыг 4,687.3 сая төгрөгөөр төлөвлөсөн ба санхүүжилт 3,076.0 сая төгрөгөөр батлагджээ.

### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайланд оны төсөв 3,076.0 сая төгрөгөөр батлагдаж, тодотголоор хянагдсанаар 2,748.2 сая төгрөгийн санхүүжилт ирсэн ба үүнээс 181.5 сая төгрөгийн хэмнэлтийг буцаан төвлөрүүлжээ. Оны нийт төсвийн гүйцэтгэл 2,566.7 сая төгрөг байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Боловсрол, соёл, урлагийн газрын нэмэлт санхүүжилт тайлант онд 399.8 сая төгрөг, тухайлбал:

- Аймгийн орон нутгийн төсвөөс 149.4 сая,
- Дээд шатны төсөв захирагч болох БШУЯ-наас 250.4 сая төгрөг тус тус орж, зориулалтын дагуу зарцуулагджээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

### 3.8 Аудитын гол асуудал

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим, сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Шатахууныг бараа материалын тайланд бөөн дүнгээр тусгасан, ариутгалын зардлыг хоёр өөр дансанд бүртгэсэн зэрэг анхаарах асуудлуудад зөвлөмж өгч, зардлын бусад бүлэгт хамруулах боломжтой зардлыг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэсэн байсныг залрууллаа. Үүнээс бусад эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэхэд зөрчил илрээгүй.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Боловсрол, соёл, урлагийн газар нь шилэн дансны цахим хуудсанд нийт 150 мэдээлэл байршуулахаас 143 мэдээллийг хугацаанд нь, 6 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба санхүүгийн тайлан, аудитын дүгнэлтийг байршуулах хугацаа болоогүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зэрэг бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шалгасан зүйлсийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэсэн болно.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Илэрсэн зөрчилд өгсөн албан шаардлагын биелэлтийг албан тоотоор гаргаж ирүүлсэн.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

2022 онд тухайн байгууллагаас Соёлын асуудал хариуцсан хэлтэс тусгаарлаж байгаа тул хөрөнгө хуваарилж хоёр байгууллагын бүртгэлд тусгасан байдалд анхаарал хандуулах шаардлагатай.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 31.0 сая төгрөгийн алдаа илэрсэн.

**4.1 Залруулсан алдаа**

Зардлын бусад бүлэгт хамруулах боломжтой 3.8 сая төгрөгийн зардлыг бараа үйлчилгээний бусад зардал дансанд бүртгэсэн байсныг залруууллаа.

**4.2 Төлбөрийн акт**

Акт тавигдаагүй.

**4.3 Албан шаардлага**

Албан шаардлага бичигдээгүй.

**4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Бараа материалын бүртгэлийн асуудал***

*1.1. Илрүүлэлт:*

Шатахууныг бараа материалын тайланд бөөн дүнгээр тусгаснаас зарцуулалтад хяналт тавихад хүндрэлтэй байна.

*1.2. Өгсөн зөвлөмж:*

Шатах тослох материалыг бараа материалд бүртгэх болон зарцуулахдаа хэмжих нэгжээр тусгаж, тайлагнаж байх.

***2. Үр дүнгийн тайланд зардал тайлагнах асуудал***

*2.1. Илрүүлэлт:*

Боловсролын байгууллагуудын ариутгалын зардлыг хоёр өөр дансанд бүртгэсэн байна.

*2.2. Өгсөн зөвлөмж:*

Ижил утгатай гүйлгээг нэг зарчмаар бүртгэж, тайлагнаж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Боловсрол, соёл, урлагийн газар | 3 | 31.0 | 1 | 3.8 | | | | | 2 | 27.2 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Б.АВИДЦЭРЭН